



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/04

Булган сум

### Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, зөвшөөрөл олгох тухай Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 526 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

2.Албан тушаалын тодорхойлолтын дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн, гүйцэтгэлийг хангаж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газарт үүрэг болгосугай.

3.Албан тушаалын тодорхойлолтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Д.Эрдэнэбилэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ